



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

**Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг тус тус зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.БААСАНДОРЖ

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

**Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын
дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7.8.7 дахь заалт, 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар баталсугай:

1.1. Нийт хөрөнгийг 68,015,906,822.96 (Жаран найман тэрбум арван таван сая есөн зуун зургаан мянга найман зуун хорин хоёр төгрөг ерэн зургаан мөнгө), үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 54,206,606,900.44 (Тавин дөрвөн тэрбум хоёр зуун зургаан сая зургаан зуун зургаан мянга есөн зуун төгрөг дөчин дөрвөн мөнгө) -өөр;

1.2. Өр төлбөрийн нийт дүнг 17,648,166,597.73 (Арван долоон тэрбум зургаан зуун дөчин найман сая нэг зуун жаран зургаан мянга таван зуун ерэн долоон төгрөг далан гурван мөнгө) -өөр;

1.3. Эзэмшигчийн өмчийг 50,367,740,225.23 (Тавин тэрбум гурван зуун жаран долоон сая долоон зуун дөчин мянга хоёр зуун хорин таван төгрөг хорин гурван мөнгө) -өөр тус тус баталсугай

2. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын хуулийн этгээдийн хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Ж.БААСАНДОРЖ



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн
талаарх дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.14 дэх заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7.8.7 дахь заалт, 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.БААСАНДОРЖ

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6, 7.10, 7.16, 7.18 дахь заалт, 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан С.Цолмон, Х.Баянбай, Ц.Норовжамц нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр, Д.Нарангэрэл, Б.Билэгдэмбэрэл, С.Ганзориг, А.Молор, Б.Төрбат, Ц.Баяр-Эрдэнэ нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс тус тус сонгосугай.

2. Ж.Цогтбаяр, Ч.Цэвэгдорж, М.Лхагважав нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүний үүрэгт ажлаас 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон тус тус чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгосугай.

3. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.БААСАНДОРЖ

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6 дахь заалт, 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг түүний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.БААСАНДОРЖ



ТУЗ-ИЙН 2024 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

/Нэгж: төгрөг/

Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал	Давтамж	Нийт дүн
1. Цалин, холбоо, тээврийн зардал				
1.1. ТУЗ-ийн гишүүний цалин	9	1,020,000	12	110,160,000
1.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1	800,000	12	9,600,000
1.3. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын холбоо, тээврийн зардал	1	150,000	12	1,880,000
Цалин, холбоо, тээврийн зардлын дүн				121,560,000
1.4. Нийгмийн даатгалын шимтгэл				15,928,080
Дэд дүн				137,488,080
2. Бичиг хэрэг, хурлын зардал				
2.1. Бичиг хэрэг, хэвлэмэл материал, цай, кофены зардал	1	180,000	12	2,160,000
2.2. Хурал зохион байгуулах байрны түрээс	1	200,000	2	400,000
2.3. Бусад зардал	1	100,000	5	500,000
Дэд дүн				3,060,000
3. ХХМТ-ийн салбар болон дэд бүтэц, холбогдох салбарын туршлага судлах, хурал, үзэсгэлэнд оролцох, сургалтын зардал				
3.1. Сургалт, семинарын зардал				8,500,000
3.2. Томилолтын зардал				34,100,000
Дэд дүн				42,600,000
НИЙТ ДҮН				183,148,080